



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/312

Номгон

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, 7 боловсрол, нийгмийн хамгааллын орон тооны бус салбар комиссыг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4, 42 дугаар зүйлийн 42.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээг тодорхойлж чиглүүлэх, 0-18 насны хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, холбон зуучлах, салбар хоорондын уялдаа холбоог хангах орон тооны бус салбар комиссыг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Салбар комиссын дарга:

В.Наранчимэг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
Гишүүд:

Ш.Сүнжидмаа Нэгдсэн эмнэлгийн Хүүхдийн тасгийн эрхлэгч

М.Дуламсүрэн Нэгдсэн эмнэлгийн Мэдрэлийн тасгийн эрхлэгч

Б.Содончимэг Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын Хүүхдийн эрхийн улсын байцаагч, хүүхдийн хөгжил хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн

Д.Цэцэнхүү Боловсрол, шинжлэх ухааны газрын Хүүхдийн хөгжил хамгаалал, тэгш хамран сургах асуудал хариуцсан мэргэжилтэн

М.Дулмаа Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын хөгжлийн төв ТББ-ын гүйцэтгэх захирал

Салбар комиссын нарийн
бичгийн дарга:

Ц.Батжаргал Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтэн

524310406

2.


2.Засгийн газрын 2021 оны 173 дугаар тогтоолоор батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын дүрэм", эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн "Жагсаалт, шалгуур үзүүлэлт, маягт шинэчлэн батлах тухай" А807, А216 дугаар хамтарсан тушаалыг хэрэгжүүлж, салбар комиссын үйл ажиллагааны тайлан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх мэдээг улирал бүрийн дараа сарын 05-ны дотор, бүтэн жилээр гаргах мэдээг 01 дүгээр сарын 10-ны дотор, жилийн ажлын төлөвлөгөө, биелэлтийг 12 дугаар сарын 10-ны дотор Засаг даргад танилцуулж ажиллахыг Салбар комиссын дарга (В.Наранчимэг)-д үүрэг болгосугай.

3.Төрийн албан хаагчийн ёс зүйг чандлан сахиж, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхыг салбар зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

5.Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/156 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН